



## МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 8 дугаар  
сарын 20 өдөр

Дугаар А./175

Улаанбаатар  
хот

"Улаанбаатар" лицей сургууль  
байгуулах тухай

1. Монгол улсын Боловсролын тухай хуулийн 16, 17, 26 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн орос хэл дээр сургалт явуулах "Улаанбаатар" лицей сургууль байгуулахыг Г.В.Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн академийн Монгол дахь төлөөлөгчдийн газрын захирал Попов М.А/-д зөвшөөрсүгэй.

2. "Улаанбаатар" лицей сургуулийг улсын бүртгэлд бүртгэж, сургалт явуулах тусгай зөвшөөрөл, хяналтын үзүүлэлтийг Боловсролын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журамд заасны дагуу олгож, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсролын мэргэжлийн комисс /Д.Хадхүү/, Боловсролын газрын дарга /П.Дорж/, Баянзүрх дүүргийн Засаг дарга /Р.Амарсайхан/-д тус тус даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД